



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/93

Жаргалант

Хагас жилийн малын түүвэр  
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 Статистикийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, аймгийн Засаг даргын А/141 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны хагас жилийн түүвэр мал тооллогын ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга :

Ж.Хүрэлбаатар

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Сэлэнгэмөрөн

Төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүдэд:

Х.Дуламсүрэн

Мал зүйч

Б.Түмэнжаргал

БОАХМэргэжилтэн

А.Цагаанхүү

Байгаль хамгаалагч

2. Мал тооллого явуулах тооллогын хэсгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Хагас жилийн түүвэр мал тооллогын ажлыг 05 дугаар сарын 25-наас 05 дугаар сарын 29 -ны дотор сонгогдсон өрхүүдэд явуулж малыг нүд үзэн тоолж тооллогын ажлыг чанартай үр дүнтэй явуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Хүрэлбаатар/-т үүрэг болгосугай.

4. Мал тооллогын мэдээллийг программд шивж нэгдсэн дүнг аймгийн статистикийн хэлтэст 06 дугаар сарын 08 -ны дотор тушаахыг Төрийн сангийн мэргэжилтэн /Б.Сэлэнгэмөрөн/ -д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ